



НИЙСЛЭЛИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын ажилтан, албан хаагчдын спортын 3-н төрөлтийн тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад орчин цагийн Биеийн тамир, спортын салбар үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ой, Монголын тамирчдын өдрийн нэрэмжит Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын ажилтан, албан хаагчдын спортын 3-н төрөлтийн тэмцээнийг 2024 оны 07 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Спортын төв ордонд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.800.000 (Нэг сая найман зуун мянган) төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Биеийн тамир, уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч (П.Ариунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс (С.Саранцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
даргын 2024 оны 07 дугаар сарын 05-ны
өдрийн 17/08 дугаар тушаалын хавсралт



Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар,
хороодын ажилтан, албан хаагчдын спортын 3-н
төрөлтийн тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Шүүгчдийн зардал: 5 хүн x 100.000 төг = 500.000 төг	500.000
2.	Багийн шагнал: 1-р байр: 600.000 төг 2-р байр: 500.000 төг 3-р байр: 200.000 төг	1.300.000
Нийт дүн		1.800.000